



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц,
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-д 694,581,681 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 817,768,643 ширхэг энгийн хувьцааны 84.94 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 84.94 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н.НАРАНГЭРЭЛ

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дах заалт, 72 дугаар зүйл, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-д санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй: Үүнд:
 - 1.1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах: зөвшөөрсөн 694,455,449 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
 - 1.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 ширхгээр нэмэгдүүлж, нийт 900,716,470 ширхэг болгох: зөвшөөрсөн 694,434,468 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 3,275 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 17,706 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
 - 1.3. Компани нь зарласан хувьцааны тоонд багтаан энгийн хувьцаа нэмж гаргахад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх: зөвшөөрсөн 694,422,224 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 31,074 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,151 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
 - 1.4. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрөх: зөвшөөрсөн 694,452,615 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,834 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
 - 1.5. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл ("Дүрэм")-ийг хавсралт ёсоор батлах: зөвшөөрсөн 694,452,615 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,834 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н.НАРАНГЭРЭЛ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дох заалт, 72.1.3 болон 75.4 дэх хэсэг, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-д цахимаар, кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дор дурдсан тоо хэмжээтэй байгааг Хуралд мэдээлсүгэй. Үүнд:

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Адилбишийн Ганхуяг	694,494,549	11.11 %
2	Адилбишийн Ганболд	694,478,759	11.11 %
3	Гансүхийн Бат-Эрдэнэ	694,458,759	11.11 %
4	Очирбатын Батмөнх	694,465,759	11.11 %
5	Ганболдын Чинзориг	694,634,094	11.11 %
6	Болдбаатарын Бат-Эрдэнэ	694,465,759	11.11 %
Хараат бус гишүүд			
1	Нямжавын Энхболд	694,368,759	11.11 %
2	Ванчигийн Ганзориг	694,355,482	11.11 %
3	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	694,377,121	11.11 %

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Н.НАРАНГЭРЭЛ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал (“Хурал”) -ын шийдвэр болон Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Зарласан энгийн хувьцааны
тоог нэмэгдүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дох заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 (Тавин сая есөн зуун тавин зургаан мянга найман зуун далан долоон) ширхгээр нэмэгдүүлж, нийт 900,716,470 (Есөн зуун сая долоон зуун арван зургаан мянга дөрвөн зуун далан) ширхэг байхаар тогтоосугай.
2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг) нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг
тэргүүн ээлжид худалдан авах эрхийг
эдлүүлэхгүй байх тухай

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дах заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь зарласан хувьцааны тоонд багтаан энгийн хувьцаа нэмж гаргахад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн Дүрэмд заасан зарласан хувьцаанаас нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, нийтэд санал болгох хугацааг тодорхойлох зэрэг хувьцаа нэмж гаргахтай холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргаж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болохыг дурдсугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Компанийн оршин байгаа хаягийг
өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн оршин байгаа хаягийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Компанийг нэмэлт өөрчлөлт орсон
дүрмийн төслийг батлах

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл ("Дүрэм")-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг
томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбишийн Ганхуяг,
 - (ii) Адилбишийн Ганболд,
 - (iii) Гансүхийн Бат-Эрдэнэ,
 - (iv) Очирбатын Батмөнх,
 - (v) Болдбаатарын Бат-Эрдэнэ,
 - (vi) Ганболдын Чинзориг.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Нямжавын Энхболд,
 - (ii) Ванчигийн Ганзориг,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

А.ГАНХУЯГ